



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/292

Улаанбаатар хот

“Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа”
эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох,
тусгай зөвшөөрөлд чиглэл нэмэх,
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн Зургадугаар бүлгийн 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3.1, 19.3.4, 19.5.3, 19.20.1, 19.21, 19.23 дахь хэсэг, Эрүүл мэндийн газрын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн яам төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 2/1126 дугаартай чиглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хуулийн этгээдүүдийг 2025 оны 09 дугаар сарын 26-ны өдрийн даргын зөвлөлийн хуралд танилцуулсны дагуу Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох 6 хуулийн этгээдийн жагсаалтыг нэгдүгээр, тусгай зөвшөөрөлд чиглэл нэмэх 2 хуулийн этгээдийн жагсаалтыг хоёрдугаар, тусгай зөвшөөрөлд чиглэл хасах 4 хуулийн этгээдийн жагсаалтыг гуравдугаар, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох 2 хуулийн хуулийн этгээдийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хууль тогтоомж, стандартад нийцүүлэн үзүүлж, эмч, мэргэжилтний чадавхийг сайжруулан, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллахыг энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтад заасан хуулийн этгээдүүдэд үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтад заасан эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгож, харьяа дүүргийн татварын байгууллагад мэдэгдэн, мэдээллийг цахим хуудаст байршуулахыг Эрүүл мэндийн тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Т.Жаргалд үүрэг болгосугай.

4. Тусгай зөвшөөрөл авснаас хойш үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтэс (Б.Батцоож)-д, тайлан, мэдээг хууль, журмын дагуу хүлээн авч нэгтгэн, дүн шинжилгээ хийх, шинээр тусгай зөвшөөрөл олгогдсон эрүүл мэндийн байгууллагын мэдээллийг газрын тайлан мэдээний санд оруулж, баяжуулалт хийн ажиллахыг Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (Д.Сайнхүү)-д нарт тус тус даалгасугай.

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, нэгдсэн удирдлагын хэлтсийн дарга (У.Бат-Очир)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.БЯМБАДОРЖ



Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 09 дүгээр сарын 30 -ны өдрийн
А/292 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ

д/д	Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нэр /Регистрийн дугаар/	Тусгай зөвшөөрлийн төрөл	Тусгай зөвшөөрлөөр эзэмших үйлчилгээний чиглэл	Хаяг
1.	ГЭТТ төгс ХХК /7005737/	Клиник	Уламжлалт анагаах ухааны оношилгоо, эмчилгээ	Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Лааганы -13 төв
2.	Бродлайн ХХК /6903541/	Клиник	Нүүр амны өвчний оношилгоо, эмчилгээ, нүүр амны согог засал	Баянгол дүүрэг 2-р хороо Баруун 4 зам, Гранд Плаза, 6 давхарт 6/7 тоот
3.	Сансарын хүрдэн ХХК /8459266/	Клиник	Уламжлалт анагаах ухааны оношилгоо, эмчилгээ	Сонгинохайрхан дүүрэг, 29-р хороо, Москва гудамж, 141/3
4.	Цэц манд сор /7011225/	Клиник	Нүүр амны өвчний оношилгоо, эмчилгээ, нүүр амны согог засал, нүүр амны гажиг засал	Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо, Стадион Оргил, Их Монгол улсын гудамж 71, Имарт Хан-Уул салбар, 3 дугаар давхарт
5.	Таван талын булаг ХХК /2563207/	Клиник	Дотрын өвчний оношилгоо, эмчилгээ	Баяндүрх дүүргийн 13 дугаар хороо, сансар гарден хотхон 39/6 байр, V-03 тоот
6.	Хуысгул ундарам ХХК /7174673/	Клиник	Нүүр амны өвчний оношилгоо, эмчилгээ	Баянзүрх дүүрэг, 37-р хороо, Өрнөх хороолол 9Б байр, 01 тоот

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн
А/292 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛД ЧИГЛЭЛ НЭМЭХ
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛ



д/д	Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нэр /регистрийн дугаар/	Тусгай зөвшөөрлийн төрөл	Одоо эрхэлж буй үйл ажиллагааны төрөл	Тусгай зөвшөөрөлд нэмэх чиглэл
1.	Интенсивкаре ХХК /5124255/	Клиник	/Гемодиализ, хөнгөвчлөх, яаралтай тусламж, үйлчилгээ/	Эрчимт эмчилгээ
2.	Реха мед ХХК /6193374/	Клиник	Эмчилгээний гоо засал	Гоо сайхны нөхөн сэргээх мэс засал

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн
4/292 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛД ЧИГЛЭЛТ ХАСАХ
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ



д/д	Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нэр /регистрийн дугаар/	Тусгай зөвшөөрлийн төрөл	Одоо эрхэлж буй үйл ажиллагааны төрөл	Тусгай зөвшөөрөлд нэмэх чиглэл
1.	Наран мөнх мед ХХК	Клиник	Эмэгтэйчүүдийн өвчний оношилгоо, эмчигээ, дүрс оношилгоо	Дүрс оношилгоо
2.	Арболд сотэцэ ХХК	Клиник	Нүүр амны оношилгоо, эмчилгээ, нүүр амны согог засал, гажиг засал	Нүүр амны согог засал
3.	Найман-Очир ХХК	Клиник	Нүүр амны оношилгоо, эмчилгээ, нүүр амны согог засал, Дотор, УАУ, Лаборатори, Дүрс оношилгоо	Нүүр амны согог засал
4.	Буянт оношилгоо ХХК	Клиник	Дотор, УАУ, Мэдрэл, Эмэгтэйчүүд, Лаборатори, Дүрс оношилгоо	Уламжлалт анагаах ухаан

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 09 дүгээр сарын 30 -ны өдрийн
А/292 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ
ХҮУЛИЙН ЭТГЭЭД



д/д	Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нэр /регистрийн дугаар/	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн дугаар	Үндэслэл
1.	Эх улаан хуст ХХК	Эмийн сан	ЭСХ-17/22/3552	Эрүүл мэндийн тухай хуулийн 19.20.1
2.	Өсөх-Ачлал ХХК	Эмийн сан	ЭСХ-17/22/3530	Эрүүл мэндийн тухай хуулийн 19.20.1